



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.2.5, 6.4.3, 6.5, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9 нэрийн, нийт 294,947.72 (хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуун дөчин долоон ам доллар далан хоёр цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Энхцэцэг, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин Сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000431

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн
337 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, агаалж, худалдах
хөрөнгийн жагсаалт

№	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашигдалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ төгрөг (ам.доллар)	Хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил
1	Хьюндай страекс /микроавтобус/, ДК 34-04 дугаартай, Арлын дугаар - KMJWAH7JP8U075315	2008/2008	210000	28,600.00	28,600.00	1,000.00	Вьентьян ЭСЯ
2	Бенз маркийн, CD AB577 дугаартай, суудлын автомашин арлын дугаар WDD2210221AO93352(01)	2011/2011.02	137163	85,873.00	85,873.00	1,000.00	Брюссель ЭСЯ
3	Тоёота Авенсис маркийн, CDAB256C дугаартай, суудлын, арлын дугаар SBIBD76L30EO14117(01)	2009/2009.03	166595	29,215.00	29,215.00	1,000.00	Брюссель ЭСЯ
4	Волсваген маркийн, CDAB528 дугаартай, суудлын, арлын дугаар KCFCFA300XO	2010/2010.11	177610	35,668.38	35,668.38	1,000.00	Брюссель ЭСЯ
5	Тоёото маркийн, GAI96-07 дугаартай, суудлын, арлын дугаар ACR50-7057407	2008/2014.01	144832	13,867.76	13,867.76	1,000.00	Токио ЭСЯ
6	Соната маркийн, ДК178 081 дугаартай, суудлын, арлын дугаар LBENFAKB07X021681	2007/2007.01	216906	20,234.45	20,234.45	1,000.00	Бээжин ЭСЯ
7	Соната маркийн, Dip075-004 дугаартай, суудлын, арлын дугаар KMNEB41ABDA557023	2013/2013.04	195380	20,223.64	20,223.64	1,000.00	Сөүл ЭСЯ
8	Старекс микроавтобус /суудлын/, Dip075-005 дугаартай, арлын дугаар KMJWA37KBEU563189	2013/2013.04	137365	23,718.18	23,718.18	1,000.00	Сөүл ЭСЯ
9	Тоёото HI Ace микро автобус /суудлын/, Рёу1113 дугаартай, арлын дугаар UFS40-5110908	2012/2012.04	72500	37,547.31	37,547.31	1,000.00	Осака ЕКГ
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			294,947.72 (хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуун дөчин долоон ам доллар далан хоёр цент)	294,947.72 (хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуун дөчин долоон ам доллар далан хоёр цент)	9,000.00 (есөн мянга ам доллар)	